



ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ



2020

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

2021 он

ӨМНӨТГӨЛ

Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) нь

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих
- Нийгэмд сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариуцлагыг бий болгох
- Сэтгүүл зүйн салбарт ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх
- Сэтгүүлчдийн хараат бус байх эрхийг хамгаалах зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд 2015 оны эхээр байгуулагдсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус, өөрийн зохицуулалтын байгууллага юм.

2020 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллага, редакцын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, иргэн, байгууллага аж ахуйн нэгжээс редакцын нийтлэл, нэвтрүүлэгт гаргасан өргөдөл гомдлыг барагдуулах үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүллээ.



2020 онд ХМЗ-д иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 52 өргөдөл гомдол ирүүлснийг Ёс зүйн хороод 6 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлээд байна.



ХМЗ-ийн Удирдах зөвлөл хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэхтэй холбоотой бодлогын шийдвэрүүдийг гаргаж, мэдэгдэл, уриалга түгээн ажиллалаа.



Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчим, сэтгүүлчийн аюулгүй байдлын сэдэвт уулзалт, сургалтуудыг хэвлэл мэдээллийн байгууллага/редакцуудад 12 удаа, ХМЗ-ийн гишүүд, ажлын албанд 4 удаагийн сургалтыг зохион байгууллаа.



Салбарын эвсэл, холбоод, редакторууд болон дотоод, гадаадын түншлэгч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллав.



Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд цахим болон хэвлэмэл танилцуулгыг түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн мэдээллийн сүлжээгээр идэвхтэй түгээлээ.




Сэтгүүл зүйн чанарын тухай хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд зориулсан хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага 6, хэвлэлийн бага хурал 1, кейс судалгаа, мониторингийн ажлыг 2 удаа тус тус зохион байгуулж, нийт 1000 гаруй хүнд хүрч ажиллажээ.

01 | ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо, Радио телевизийн Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг ХМЗ НҮТББ-ын дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан хэлэлцэж дүгнэлтээ гаргадаг.


Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оноос 2020 оныг дуустал нийт 385 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэжээ.

Хэвлэл мэдээллийн зөвлөлд иргэдээс ирүүлсэн
гомдлын тоо /2015-2020 онд/



2020 оны нэгдүгээр сараас арванхоёрдугаар сар хүртэлх хугацаанд нийт 52 өргөдөл гомдлыг хүлээн авсан. Үүнээс:

- РТВ-ийн Ёс зүйн хороонд 10 (19%)
- ССС-ын Ёс зүйн хороонд 42 (81%) гомдол тус тус хаяглагдсан байна.



ХМЗ-өөс өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Нийт 52 өргөдлийн 23-г ГХАБЖ-ын 2.3-ын дагуу хугацаа хэтэрсэн, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй, ХМЗ-ийн чиг үүрэгт хамаарахгүй, гомдол үндэслэлгүй зэрэг шалтгаанаар Ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн.

9 гомдол гаргагч өргөдлөө буцаан татсан.

Ингээд 22 сэтгүүл зүйн бүтээлд (2019 онд шүүхийн шийдвэр гартал түр хойшлуулсан 1 гомдол, жилийн эцсээр ирсэн 1, нийт 2 гомдлыг нэмж хэлэлцсэн болно) хаягласан гомдлыг хоёр Хорооны 6 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, ӨГБЖ-ын 6.3-ийн дагуу дараах дүгнэлтийг гаргасан.


- I. ӨГБЖ-ын 6.3.1-ийн дагуу 10 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгийг олон нийтэд мэдээлэх;
- II. ӨГБЖ-ын 6.3.2-ын дагуу 3 редакцыг зөрчлөө өөрсдөө залруулсан, уучлал гуйсныг мэдэгдэж, нэрийг дурьдахгүйгээр олон нийтэд мэдээлэх;
- III. ӨГБЖ-ын 6.3.3-ийн дагуу 9 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн тул нэрийг дурьдаж олон нийтэд мэдээлэх зэрэг болно.

Ёс зүйн хороодын дүгнэлтээс харахад хариуцагч хэвлэл мэдээллийн редакцууд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дараах заалтуудыг нийтлэг зөрчжээ. Үүнд:

- 1.1-т заасан “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”
- 1.2-т заасан “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ” гэсэн заалтууд багтаж байна.



ХМЗ-д гомдол гаргагсдыг ангилж харвал

- Хувь хүн 54 хувь
- Улс төрч, төрийн албан хаагч, төрийн байгууллага 20 хувь
- Бизнесийн байгууллага 15 хувь
- Бусад 11 хувь байна.



Харьцуулалт

2020 оны 10 дугаар сарын байдлаар “Худал мэдээлэл тараах” заалтыг агуулсан холбогдох хуулиудыг зөрчсөн эсэх асуудлаар Прокурорын байгууллагад 206 хүн шалгагдсанаас 18 нь сэтгүүлчтэй холбоотой байна.



Харин 2020 онд Хэвлэл мэдээллийн зөвлөлд иргэн, байгууллагаас редакцын сэтгүүл зүйн агуулга нь ёс зүйн зарчим зөрчсөн, худал мэдээлэл агуулсан гэсэн 52 гомдлыг хаяглажээ. Сэтгүүл зүйн агуулгын чанарын хяналтыг хуулиар бус ёс зүйн зарчмын хүрээнд нь хэлэлцэх боломжтой гэдгийг иргэдийн гурав дахин илүү оролцоо харуулж байгаа юм.



02 | УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БОДЛОГЫН ШИЙДВЭРҮҮД:

ХМЗ-ийн Удирдах зөвлөл нь сонин/сэтгүүл, радио/телевиз, цахим сайтууд, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийт/санаачлагчдын бүлэг гэсэн таван салбар бүлгийг төлөөлөх 15 хүний бүрэлдэхүүнтэй.

ХМЗ НҮТББ-ын дүрмийн 10.2-т заасны дагуу ажлын албанаас санал оруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж чиг үүрэг өгөхөөс гадна хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэхтэй холбоотой бодлогын шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа.

2020 онд ХМЗ-ийн Удирдах зөвлөл 8 удаагийн хурал хийж, дараах бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн баталжээ.

1. ХЗДХЯ-ны дэргэдэх Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгээс ХМЗ гарах тухай шийдвэр гаргав (2-р сарын 21)
2. Сонгуулийн сурталчилгааны үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гомдол хүлээн авах, барагдуулах түр журмыг батлав (5-р сарын 19)
3. Удирдах зөвлөлд сайтын эздийн төлөөлөл болгон МҮСХНХ-ны Дэд ерөнхийлөгч Л.Цэрэнжаргалыг, РТВ ёс зүйн хороонд олон нийтийн төлөөлөл болгон Хүний эрхийн хамгаалагч Б.Болорсайханыг сонгов (5-р сарын 19)
4. ХМЗ-ийн Удирдах зөвлөлд цахим сайтын сэтгүүлчдийн төлөөлөл болгон Time.mn сайтын эрхлэгч Г.Улсболдыг сонгов (11-р сарын 10)
5. Эрүүгийн хуулийн 13.14 “Худал мэдээлэл тараах” заалтад нэмэлт өөрчлөлт оруулахыг ХМЗ эсэргүүцэж буйгаа илэрхийлэв (12-р сарын 12)

Түүнчлэн Удирдах зөвлөлийн гишүүд хоёр удаагийн сургалтад хамрагдаж, ХМЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах, бие даасан хараат бус өөрийн зохицуулалтын байгууллагыг санхүүгийн хувьд тогтвортой хөгжүүлэх төлөвлөгөө зэргийг хэлэлцлээ.



03 | “ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БОДЛОГО” ЦУВРАЛ ДУГУЙ ШИРЭЭНИЙ ЯРИЛЦЛАГА

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Фридрих-Эбертийн Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран “Хэвлэл мэдээллийн бодлого” цуврал дугуй ширээний ярилцлагыг 2018 онд эхлүүлсэн. Уг уламжлалын дагуу 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр “Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн зохицуулалт ба ёс зүй” сэдвийн хүрээнд ярилцлагыг зохион байгууллаа.



Энэ удаагийн дугуй ширээний ярилцлагын гол зорилго нь цар тахлын онцгой нөхцөлд зохион байгуулагдсан УИХ-ын сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт болон хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт ба ёс зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг тал бүрийн мэргэжилтнүүд хэлэлцэж, гарц шийдэл хайх явдал байв.

Сэтгүүлчид болон редакторууд, ХМЗ-ийн гишүүд, хуульч, эрх зүйчид болон ХХЗХ, СЕХ, МУЕПГ-ын төлөөлөл оролцсон энэхүү ярилцлагаар “УИХ-ын сонгуулийн жилд хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд холбогдох хэргийн шийдвэрлэлт”, “Телевизүүд сонгуулийн сурталчилгааны хугацаанд ёс зүйн зарчмаа мөрдсөн үү?” гэсэн хоёр төрлийн судалгааны үр дүнг танилцуулсан юм. Мөн “Сонгуулийн үеийн сэтгүүл зүйн чанар, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр нөлөө” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

Хэлэлцүүлэгт оролцогсод өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэж болох харилцааг Эрүүгийн хууль болон бусад хуулиар шийдвэрлэх болсон нь сэтгүүл зүйн чөлөөт шүүмжлэлийг хүмийх оролдлого болж буйг онцолсон. Мөн сонгуулийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх



сурталчилгааны хэмжээг тун багаар тогтоосон нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, нэвтрүүлгийг хязгаартайгаар бэлдэхэд хүргэсэн, улмаар “сурталчилгаа”, “сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл” гэх зэрэг хуулийн нэр томьёоны ойлголтуудыг тодорхой болгох шаардлагатай байгааг дурдсан юм. Түүнчлэн дараа дараагийн сонгуулийн тухай хуулиуд батлагдахаас өмнө хэвлэлийн салбарын холбоод, сэтгүүлчид нэгдэн, дотроо хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төсөлд саналаа нэгтгэж өгөх, зөвхөн өгөөд зогсохгүй батлагдах шат хүртэл тууштай ажиллах шаардлага байгаа дээр оролцогчид санал нэгдсэн билээ.



04 | СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧАНАРЫН ЦУВРАЛ СУРГАЛТ, УУЛЗАЛТУУД

Дөрөвдүгээр сар

ХМЗ-өөс Хэвлэлийн Омбудсмен олон улсын байгууллагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэнд зориулан коронавируст халдварын талаар мэдээ, сурвалжилга бэлдэхдээ баримтлах зарчим бүхий зөвлөмж гаргасныг орчуулан хүргэлээ.



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19) БА РЕДАКЦЫН БАРИМТЛАХ СТАНДАРТ


Хэвлэлийн Омбудсмен олон улсын байгууллагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэнд зориулан коронавируст халдварын талаар мэдээ, сурвалжилга бэлдэхдээ баримтлах зарчим бүхий зөвлөмж гаргасныг ХМЗ-өөс орчуулан хүргэж байна. Англи хэл дээрх хувилбарыг эндээс үзэх боломжтой.

COVID-19 буюу шинэ коронавируст халдварын тухай мэдээлэл хамгийн эрэлттэй, өдөр тутмын анхаарал татсан мэдээлэл болоод байгаа төдийгүй цаашид хэсэг хугацаанд энэ байдал хадгалагдах төлөвтэй байна.

Шуурхай, нөлөө ихтэй энэ мэт асуудлыг сурвалжлах үед сэтгүүлчид ачаалал ихтэй ажилладаг. Тэд хурдтай хуусан өөрчлөгдөж буй асуудлыг сурвалжлахдаа уртасгасан цагаар, ихэнх тохиолдолд биеийн болон сэтгэл зүйн эрсдэлтэй нөхцөлд ажилладаг. Тиймээс хэвлэл мэдээллийн байгууллагууд ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал хандуулах хэрэгтэй.

1-12 дугаар сар

ХМЗ-ийн ажлын албанаас редакцуудын уулзалтыг тогтмол хийж, нийт 13 хэвлэл мэдээллийн байгууллагад зочлон, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, ёс зүйн зарчим, сэтгүүлчийн аюулгүй байдлын талаар мэдээлэл хийлээ. Үүнд Ардчилал таймс болон Үндэсний шуудан сонин, Gogo.mn болон Tovch.mn, Eguur.mn, Erennews.mn, Urug.mn, Livetv.mn, Time.mn сайтууд, The Mongolian Mining Journal сэтгүүл, TB9, NTV болон C1 телевиз багтаж байна.





Дөрөвдүгээр сар

Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг цар тахлын үед Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмаа чанд мөрдөж ажиллахыг уриалж, зөвлөмж гаргалаа. Ковид-19 цар тахлын үед үнэн бодит байдлыг эрхэмлэх, олон ургальч мэдээллээр хангах, мэдээллийг дахин нягтлах, ялгаварлан гадуурхахгүй, доромжлохгүй байх, хувийн нууцад хүндэтгэлтэй хандахыг онцгой анхаарахыг сануулсан.

Covid-19!!! Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс зөвлөж байна!

Онцгой байдалд редакцын баримтлах ёс зүйн зарчим

COVID-19 онцгой нөхцөл байдлын үед ирээдүй худал мэдээлэл тарахаас сэргийлэх, сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагаа хэвлэлийн эрх чөлөөнд халайгаар үйл ажиллагаагаа саадгүй явуулахыг дэмжих зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс дараах зөвлөмжийг хүргэж байна.

Онцгой нөхцөлд хэвлэл мэдээллийн редакцууд мэргэжлийн түвшинд, ёс зүйн зарчмаа баримтлан ажиллах, бодит мэдээлэл түгээснээр олон нийтийг зөв үйлдэлд чиглүүлнэ. "Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим"-ыг өдөр тутмын сэтгүүл зүйн үйл ажиллагаандаа чанд сахин мөрдөхөөс гадна дараах ёс зүйн зарчмуудад онцгойлон анхаарлаа хандуулахыг зөвлөж байна.

- **Үнэн бодит байдлыг эрхэмлэх:** Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийн үнэн зөвийг танхих эхний алхам нь мэдээллийг түгээгч нь найдвартай, баталгаатай эх сурвалж мөн эсхийг нягтал. Мэдээллийг түгээхдээ хүнлэг байх, олон нийтийг айдас, хүйдэс, эрсдэлт талгүй нөхцөл байдал руу хөтлөхөөс болгоомжилж, зөвхөн үнэнд нийцсэн мэдээллийг түгээхэд анхаарна.
- **Олон ургальч мэдээллээр хангах:** Албан ёсны эх сурвалжийн мэдээллээс гадна эрүүл мэндийн чиглэлийн эрдэмтэн судлаачдын байр суурь, халдвар судлалын шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг баримт бичгүүд, халдварт өвчин нь нийгмийн бусад салбарт хэрхэн нөлөөлж буй талаарх судлаачдын ажиглалт, тандалтыг олон нийтэд түгээж, тэдний шийдвэр гаргалтад зөвөөр туслахыг хичээнэ.

Тавдугаар сар

"COVID19!!! Хямралын үеийн хэвлэлийн эрх чөлөө" сэдэвт цахим хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэвлэл мэдээллийн салбарын төлөөллүүд оролцсон уг хэлэлцүүлгийн үеэр МУИС-ийн Хууль зүйн сургуулийн доктор, профессор О.Мөнхсайхан "Цар тахлын хууль ба хүний эрх, хэвлэлийн эрх чөлөө", ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа "Онцгой байдалд хэвлэл мэдээллийн баримтлах ёс зүй", Германы Хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга Манфред Протце "Хямралын үед сэтгүүл зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг" сэдвээр мэдээлэл хийж, оролцогчдын санал бодлыг сонсов.



Аравдугаар сар

"Цар тахлын үеийн редакцын бодлого ба өөрийн зохицуулалт" сэдэвт редакторуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын үр дүнд цар тахлын үеэр иргэдийн үнэнийг мэдэх эрхийг тэргүүнд тавьж, олон талын эх сурвалжаар баталгаажсан мэдээлэл бэлтгэх зорилгоо ухамсарлахын зэрэгцээ баталгаатай бус мэдээлэл түгээхээс сэргийлж, мэдээллийг нягтлан шалгадаг үр чадвараа улам хөгжүүлэх, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг чанд мөрдөн ажиллахыг редакцуудад уриаллаа.



Дөрөвдүгээр сар

ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүдэд зориулсан “Худал мэдээлэл ба COVID-19” цахим сургалтыг зохион байгуулав. Сургагч багшаар МУИС-ийн Хууль зүйн сургуулийн доктор, профессор О.Мөнхсайхан оролцож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлтөөр орсон “Илт худал мэдээлэл тараах” тухай заалт, түүний хэрэглээ, үр дагаврын талаар болон COVID-19 зэрэг онцгой байдлын үеэр гарч болох тохиолдол, эрсдэлийн талаар хэлэлцлээ.

Тавдугаар сар

Хэвлэл мэдээллийн редакцуудыг УИХ-ын ээлжит сонгуулийг ёс зүйтэй мэдээлж, сурвалжлахыг уриаллаа. Энэ удаагийн сонгуулийг цар тахлын онцгой нөхцөл байдалд зохион байгуулж буй тул сонгуулийн сурталчилгааны үеэр хүний эрхийг дээдлэх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, худал мэдээлэл, гүтгэлэг, доромжлолоос ангид байж аливаа мэдээ, мэдээллийг түгээхдээ хянамгай хандан, санамсаргүй алдаа гаргахаас сэргийлж, олон талын эх сурвалжаар баталгаажуулах, мэргэжлийн ёс зүйгээ чанд баримтлан ажиллахыг уриалсан юм.

Хэвлэл мэдээллийн редакцуудыг сонгуулийн үеэр ёс зүйтэй ажиллахыг уриалж байна

УРИАЛГА

Монгол Улс 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийг онцгой нөхцөл байдалд, олон сорилтын дунд хийх гэж байна. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, чөлөөт шүүмжлэл өрнүүлэх, зөвлөлдөн нэгдэх зэрэг хүний үндсэн буюу жам ёсны эрхээ хэрэгжүүлэх боломжтой нөхцөлд ард иргэд улс төрийн сонголтоо бүрэн дүүрэн, итгэл төгс хийж чадна. Иймд цар тахлын үеийн чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн үйл явцад Чөлөөт Хэвлэл Мэдээлэл, МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛЧДИЙН үүрэг, хариуцлага үлэмж их юм.

Сонгуулийн үед хамгийн түгээмэл ажиглагддаг худал мэдээлэл, гүтгэлэг, доромжлолоос мэргэжлийн сэтгүүлч, редакторууд ангид байж, ийм зүйлийг нийтлэх, түгээхээс татгалзах ёстой. Үүний тулд сэтгүүлч, сурвалжлагч та бүхнийг аливаа мэдээ, мэдээллийг түгээхдээ туйлын хянуур байж, санамсаргүй алдаа гаргахаас сэргийлэн, олон талын эх сурвалжаар баталгаажуулсны дараа хэвлэл мэдээллийн хэрэгслээрээ түгээхийг онцлон анхааруулж байна.

Редакцын бэлтгэсэн мэргэжлийн контентийн агуулгаас үзэл суртал шингэсэн болон төлбөртэй мэдээллийг тодорхой тэмдэглэн заагаж, хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүй байх нь сэтгүүл зүйн зарчим. Энэ нь нэг талаар иргэдийн мэдэх эрхийг хангах, нөгөөтэйгүүр тухайн редакцын ил тод нээлттэй байдлын хэмжүүр болно.

Аравдугаар сар

ХМЗ-ийн бүх гишүүдийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт, гомдол шийдвэрлэх үйл явцад баримтлах зарчим болон анхаарах зүйлс, чанарын сайжруулалт, ёс зүйн зарчмыг хангахад редакцын бодлого хэрхэн нөлөөлөх талаар болоод 2018-2020 оны үйл ажиллагааны тайлан зэргийг хэлэлцлээ. Сургалтад ХМЗ-ийн удирдах зөвлөлийн дэд дарга У.Тамир, РТВ-ийн ёс зүйн хорооны орлогч дарга Ц.Чимиддондог, гишүүн Б.Болорсайхан, CCC-ын ёс зүйн хорооны гишүүн Д.Нарантуяа, О.Ариунбилэг, Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа нар мэдээлэл хийж, илтгэл танилцуулсан юм.



Аравдугаар сар

Төв Азийн хэвлэл мэдээллийн 22-р бага хурал цахимаар зохион байгуулагдав. Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны нийгэмлэгээс зохион байгуулсан тус бага хуралд ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа оролцож, “Цар тахлын үеийн Монголын хэвлэл мэдээллийн байдал” сэдвийн хүрээнд илтгэл танилцуулсан.



Аравдугаар сар

“Хэвлэл мэдээллийн бодлого” цуврал дугуй ширээний ярилцлагыг “Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн зохицуулалт ба ёс зүй” сэдвийн хүрээнд Фридрих-Эбертийн сантай хамтран зохион байгуулав.



Аравдугаар сар

Дэлхийн Зөн олон улсын байгууллага, Хөөрхөн зүрх ТББ, Европын холбооноос Монгол улсад суугаа төлөөлөгчийн газар хамтран зохион байгуулсан “Хэвлэл мэдээллийн оролцоо ба цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг хүчирхийлэл” сэдэвт сургалтад ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа сургагчаар оролцсон. “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтаар хүүхдийн эрхийг хамгаалах нь” агуулгын хүрээнд Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн төлөв байдал, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт ба хүүхэд хамгаалал сэдвийн хүрээнд мэдээлэл солилцов.




Арваннэгдүгээр сар

“Бүх нийтийн бэлэн байдлын үед сэтгүүл зүйд тулгарч буй асуудлууд” сэдэвт цахим уулзалтыг зохион байгуулав. Цахим уулзалтад сэтгүүлч, редакторууд оролцон цар тахлаас шалтгаалан бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн цаг үед сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэхэд тулгарч буй асуудал, бэрхшээлийн талаар санал бодлоо солилцлоо.



Арванхоёрдугаар сар

“Хэвлэл мэдээллийн салбарын эвсэл холбоодын хамтарсан уулзалт”-ыг цахимаар зохион байгуулсан. Уулзалтаар бүх нийтийн бэлэн байдлын үед иргэн бүрийн суурь эрх болох үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт хэр түвшинд байгаа, мэдээ сурвалжилга бэлтгэн түгээхэд сэтгүүлчдэд ямар саад бэрхшээл тулгарч буй талаар хэлэлцэж, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинтой холбоотой асуудалд салбарын эвсэл, холбоод уялдаа холбоотой, хамтран ажиллахаар болов.




Арванхоёрдугаар сар

ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн ээлжит бүс хурлыг зохион байгуулж, Эрүүгийн хуулийн 13.14 дэх “Худал мэдээлэл тараах, түгээх” заалтад ХЗДХЯ нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийн санал боловсруулсантай холбогдуулан ХМЗ-ийн байр суурийг нэгтгэсэн. УЗ-ийн зүгээс ХЗДХЯ-наас боловсруулан вэб сайтдаа байршуулсан уг хуулийн төсөл нь холбогдох мэргэжлийн байгууллагууд болон олон нийтээс санал авалгүйгээр Хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчин Засгийн газрын хуралдаанд оруулахаар болсныг эсэргүүцэж байна. Иймээс бусад эвсэл, холбоодтой нэгдэж хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулахгүй байх талаас шахалт үзүүлэх шаардлагатай гэж үзсэн юм.

Арванхоёрдугаар сар

“Бүх нийтийн бэлэн байдлын үеийн хэвлэлийн эрх чөлөө” судалгааг хийв. Энэхүү судалгаанд 300 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг хамруулсан бөгөөд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүл зүйд тулгарч буй асуудлуудыг тодорхойлох, тэдгээрийг шийдвэрлэх гарцыг тодорхойлох зорилготой байв.



Арванхоёрдугаар сар

ХЗДХЯ-аас ажлын хэсгийг байгуулж, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн батлуулахаа мэдэгдсэнтэй холбоотойгоор ХМЗ-ийн бүх гишүүдийн цахим уулзалтууд болов. Уг хуулийн төслийн нэг бүлэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ёс зүйн асуудлыг хариуцдаг Хэвлэл мэдээллийн зөвлөлийг хуулиар шинэчлэн байгуулах тухай мэдэгдсэн нь хэвлэлийн эрх чөлөө, хараат бүс байдалд маш хортой, аюул учруулах мэдэгдэл хэмээн ХМЗ-ийн байр суурийг тодорхойлсон. Түүнчлэн хуулийн төслийг амжилттай хэлэлцүүлэхэд хэвлэл мэдээллийн салбарынханы нэгдсэн ойлголт, байр суурь чухал тул бусад эвсэл холбоодтой хамтран ажиллахыг чухалчлав.

**ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АЖЛЫН ХЭСЭГТ САЛБАРЫН
ЭВСЭЛ, ХОЛБООДЫГ НЭГДЭН
АЖИЛЛАХЫГ УРИАЛЖ БАЙНА**

МСНЗ-ээс 2020 оны 12 дугаар сарын 17-нд зохион байгуулсан хэвлэл мэдээллийн эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн хуралдаанаар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах дөрвөн ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Хэвлэл мэдээллийн зөвлөл хуулийн ажлын хэсгийг ахалж ажиллахаар боллоо. Иймээс 12 дугаар сарын 18-нд 20 гаруй эвсэл, холбоо, мэргэжлийн байгууллагуудад уг хуулийн төслийн ажлын хэсэгт төлөөлөө ирүүлэхийг хүсэж албан бичиг хүргүүлээ. Үүнд:


Арванхоёрдугаар сар

Хэвлэл мэдээллийн эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн хуралдаанаар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах дөрвөн ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Хэвлэл мэдээллийн зөвлөл хуулийн ажлын хэсгийг чиглүүлэн зохион байгуулах үүргийг хүлээв. Иймээс 12 сарын 18-нд 20 гаруй эвсэл, холбоо, мэргэжлийн байгууллагуудад уг хуулийн төслийн ажлын хэсэгт төлөөллөө ирүүлэхийг хүсэж албан бичиг хүргүүлсэн.

- Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл
- Глоб интернэшнл төв
- Хэвлэлийн хүрээлэн
- Монголын телевизүүдийн холбоо
- Монголын өдөр тутмын сонины холбоо
- Парламентын сэтгүүлчдийн холбоо
- Монголын сайтын холбоо
- Монголын үндэсний сайтуудын хөгжлийн нэгдсэн холбоо
- Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо
- Хангарьд Улаанбаатарын сэтгүүлчдийн холбоо
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо
- Орон нутгийн телевизүүдийн холбоо
- Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв
- Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн эв нэгдэл ТББ
- Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клуб ТББ
- Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо ТББ
- Монголын криминологичдын холбоо
- Монголын гэрэл зурагчдын холбоо
- Талын түрлэг ТББ
- Монголын Олон Нийтийн Медиа Контент Сан
- Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төв



Арванхоёрдугаар сар

Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо, Орон нутгийн телевизүүдийн холбоотой хамтран “Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, цаг үеийн асуудлууд” сэдэвт цахим хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт 21 аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл, ХМЗ-ийн төлөөлөл бүхий 40 орчим хүн оролцов. Цахим уулзалтаар ХЗДХЯ-наас танилцуулж буй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрүүгийн хуулийн 13.14 дэх заалтын төсөл, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтад төрөөс ямар нэгэн оролцоо байж болох эсэх зэрэг агуулгын хүрээнд мэдээлэл өгч, санал солилцсон.



Арванхоёрдугаар сар

ХМЗ-ийн санхүүгийн хараат бус, тогтвортой байдлыг хангах тухай зөвлөлдөх уулзалтыг цахимаар зохион байгуулав. Уулзалтад ХМЗ-ийн УЗ-ийн гишүүд болон ХБНГУ-ын Хэвлэлийн зөвлөлийн гишүүн Манфред Протце нар оролцсон. Уулзалтаар ХМЗ-ийг дэмжих хараат бус байгууллага үүсгэн байгуулах нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хараат бус “шүүх”-ийн үүрэг гүйцэтгэхэд чухал нөлөөтэй тул гишүүд дэмжиж, УЗ-өөс цаашид ажлын хэсэг байгуулж бэлтгэл хангаж ажиллах нь зүйтэй хэмээн үзлээ.



05 | ОЛОН НИЙТЭД ХАНДСАН АЖЛУУД

● ХМЗ-өөс цар тахлын үед хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой хуулийн заалтуудад нухацтай хандахыг УИХ-ын дарга болон гишүүдэд анхааруулан албан бичиг хүргүүлэв. Уг албан бичигт Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төсөл болон Гамшгаас хамгаалах тухай, Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслүүдэд хэвлэлийн эрх чөлөөнд халтай зарим зүйл заалт байгаа талаар санал, шүүмж илгээсэн юм. (Дөрөвдүгээр сар)



Хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотой заалтуудад нухацтай хандахыг УИХ-д анхаарууллаа

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танаа

Хэвлэл мэдээллийн зөвлөл, Глоб интернэшн төв ТББ-ууд нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, олон нийтийн баталгаатай, үнэн бодит мэдээлэл авах эрхийг хамгаалах, сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн байгууллагуудын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх зорилготой ашгийн бүс олон нийтийн байгууллагууд юм. Сэтгүүл зүйн ёс зүй, хэвлэл мэдээллийн редакцийн хариуцлагыг бид зөвлөн хам хэмжээ буюу хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтаар шийдвэрлэх нь урт хугацаандаа илүү үр өгөөжтэй хэмээн үздэг. Иймээс ХМЗ нь хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг зөрчсөн хэмээн үзэж буй иргэн, аж ахуйн нэгжийн өргөдөл гомдлыг үнэ төлбөргүй хүлээн авч, өөрийн дүрэм журмынхаа хүрээнд шударгаар хэлэлцэн дүгнэлт гаргадаг. Үүний зэрэгцээ хэвлэлийн эрх чөлөө, үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хангахтай холбоотой хууль, журмын төслүүдэд манай байгууллагууд саналаа нэгтгэн, хамтран илэрхийлсээр ирсэн.

● ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, СССР-ын ёс зүйн хорооны гишүүн О.Ариунбилэг нар УИХ-ын 2020 оны сонгуулийн сурталчилгааны үеэр ХМЗ сэтгүүл зүйн бүтээлтэй холбоотой иргэн болон нэр



дэвшигчдээс ирүүлэх өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч, шийдвэрлэх болсон талаар болон ХМЗ-өөс сонгуулийн үеэр редакцын баримтлах бодлогыг мөрдөж ажиллах тухай олон нийтэд мэдээлэв. (Зургадугаар сар)

● Гомдол хүлээж авах, барагдуулах журмын хэрэгжилтийн дагуу ХМЗ-ийн хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар 6 удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтэд нээлттэйгээр байршууллаа. (<http://www.mediacouncil.mn/as/shiidver>) Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээв.



ЁС ЗҮЙН ХОРОО ШИЙДВЭРЭЭ ГАРГАЛАА

● ХМЗ-өөс Эрүүгийн хуулийн 13.14 дэх “Худал мэдээлэл тараах, түгээх” заалтад нэмэлт өөрчлөлт оруулахыг эсэргүүцэн 12 дугаар сарын 13-ны өдөр мэдэгдэл гаргасан.



ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 13.14- ИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙГ ХМЗ ЭРС ЭСЭРГҮҮЦЭЖ БАЙНА

Хэвлэл мэдээллийн зөвлөл /ХМЗ/-ийн Удирдах зөвлөлийн ээлжит бүс хурлыг 2020 оны арванхоёрдугаар сарын 12-нд зохион байгууллаа. Энэ удаагийн хурлаар Эрүүгийн хуулийн 13.14 дэх “Худал мэдээлэл тараах, түгээх” заалтад ХЗДХЯ нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийн санал боловсруулсантай холбогдуулан ХМЗ-ийн байр суурийг нэгтгэх, энэ талаар хэлэлцэж цаашид ямар арга хэмжээ авч ажиллах талаар Удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцлээ. Уг хурлаар дараах байр суурийг нэгтгэсэн болно.

ХЗДХЯ-наас боловсруулан өвч сайтдаа байршуулсан уг хуулийн төсөл нь холбогдох мэргэжлийн байгууллагууд болон олон нийтээс санал авалгүйгээр хууль тогтоомжийн тухай хуулийг зөрчин арванхоёрдугаар сарын 16-ны Засгийн газрын хуралдаанд оруулахаар болсоныг ХМЗ эрс эсэргүүцэж байна. Иймээс бусад эвсэл, холбоотой нэгдэж хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд оруулахгүй байх талаас шахалт үзүүлэх шаардлагатай гэж үзлээ.

ХЗДХЯ уг хуулийн төслийг боловсруулснаараа Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Үндсэн хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зэрэг олон хууль тогтоомжийг зөрчиж байна. Иргэний нэр төр, андас хүндийг хамгаалах, нийгэмд эх замбарлагүй байдал үүсэх эрсдэлээс хамгаалсан зохицуулалтууд нь бусад олон хууль тогтоомжид баталгаажсан байдгийг дахварлуулсаныг Удирдах зөвлөлийн гишүүд эрс буруушаасан юм.

- Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд улирал тутам цахим сэтгүүл гаргаж, олон нийтэд түгээж байна. Өнгөрсөн онд нийт дөрвөн дугаар гаргаж дотоодын 700 гаруй, гадаадын 100 орчим хүнд илгээв.



- ХМЗ-ийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүжилтийн талаарх мэдээлэл бүхий жилийн тайланг хэвлүүлж, 2018 оны тайлангийн хамтаар 100 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага, дэмжигч байгууллагуудад хүргүүлэв. “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого”, “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг”-ийг санаачлан боловсруулж, салбарын эвсэл холбоод, редакцуудад хүргүүлэв.

Эдгээрийг www.mediacouncil.mn сайтад олон нийтэд нээлттэйгээр байршуулав.



- ХМЗ-ийн өргөдөл гомдлын статистик мэдээлэл болон Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг агуулсан танилцуулгыг хэвлүүлж мөн иргэд болон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нээлттэй түгээж байна.



- Хэвлэл мэдээллийн ёс зүйн өдрийг 9 дүгээр сарын сүүлийн долоо хоногт уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлэв. Үүнтэй уялдуулан Хэвлэл мэдээллийн зөвлөл өөрийн нийгмийн сүлжээний хуудсуудаар дамжуулан ёс зүйн зарчмаа баримтлан ажиллах уриалга бүхий мэдээлэл сурталчилгааны ажлыг явуулав. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Ёс зүйн асуудал яагаад чухал вэ хэмээх сэдвийн хүрээнд видео контентууд бэлтгэн түгээв.

- Цар тахлын онцгой нөхцөл байдалд сэтгүүлчид хэрхэн ажиллах тухай редакторуудын байр суурийг илтгэсэн постерууд бэлтгэн түгээв.




- ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа Өдрийн сонинд “Улс орнууд худал мэдээллийг Эрүүгийн хуулиар зохицуулахын эсрэг байр суурьтай байгаа” сэдвээр ярилцлага өгөв.

Иргэдийн үг хэлж, үзэл бодлоо илэрхийлэх эрх ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт



● “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” гарын авлагыг 15 хэсэг бүхий карт байдлаар гаргаж, хэвлэмэл (1000 хувь) болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээв. Гарын авлагын агуулгад Чөлөөт, хараат бус хэвлэл, Мэдэх эрх ба өөрийн зохицуулалт, Сэтгүүлчийн ёс зүй,

Хүний эрх ба хэвлэл мэдээлэл, Зөрчигдсөн эрхээ сэргээх нь, Иргэний гомдлыг барагдуулах нь зэрэг сэдвүүдийг багтаав. Гарын авлагыг Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр бүтээсэн юм.



● Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сонгуулийн сурталчилгаа болон цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөөний асуудлыг талаар

редакторууд, салбарын мэргэжилтнүүдийн үзэл бодол бүхий эшлэлийг бэлдэж цахимаар түгээлээ.



● Цар тахлын үеийн хэвлэлийн эрх чөлөөний асуудал, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчлэл, Эрүүгийн хуулийн 13.14-ийн нэмэлт өөрчлөлтийн санал, Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын талаар хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч, зочноор оролцон мөн мэдээ нийтлэлд эх сурвалжаар

оролцжээ. Энэ хүрээнд ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа TB9, Live TB, C1, NTV, Монгол ТВ, Tovch.mn, Mass.mn, Өнөөдөр сонин, Gogo.mn сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлж, олон нийтэд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тухай мэдээ мэдээлэл өгчээ.



06 | МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

ХМЗ-өөс 2020 онд дараах гарын авлага, танилцуулга, тараах материал, сурталчилгааны бүтээгдэхүүнийг бэлтгэж, сэтгүүл зүйн салбарынхан болон бусад зорилтот бүлэгт түгээв.



ХМЗ-ийн 2019- 2020 оны үйл ажиллагааны тайлан

500 ш



Хэвлэл мэдээллийн гомдлын статистик, ёс зүйн зарчим танилцуулга

250 ш



“Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого” гарын авлага

500 ш



“Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг” гарын авлага

500 ш



“Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” гарын авлага

1000 ш

“Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт ба ёс зүй” мониторингийн тайлан

300 ш




07 | ДОТООДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

 Салбарын эвсэл холбоодтой хамтарч ажиллав.

- » “Хэвлэл мэдээллийн салбарын эвсэл холбоодын хамтарсан цахим уулзалт”-ыг зохион байгуулав. Хэвлэл мэдээллийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, эвсэл, холбоод уялдаа холбоотой, хамтран ажиллахаар болов. Хэвлэлийн эрх чөлөө, мэдээллийн ил тод байдал, хэвлэл мэдээллийн салбарын тогтвортой хөгжлийн асуудлаар тулгамдсан гурван асуудлыг сонгон авч гурван багт хуваагдан ажиллахаар болсон юм.
- » Салбарын эвсэл, холбоодын хамтарсан уулзалт болж Эрүүгийн хуулийн 13.14 дэх “Худал мэдээлэл тараах, түгээх” заалтад нэмэлт өөрчлөлт оруулахыг эсэргүүцсэн албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.
- » МСНЭ-ээс 2020 оны 12 дугаар сарын 17-нд зохион байгуулсан хэвлэл мэдээллийн эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын нэгдсэн хуралдаанаар Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах чиглэлээр Үндэсний түр зөвлөл байгуулж, дөрвөн дэд ажлын хэсгийг байгуулсан. Энэ хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөл хуулийн ажлын хэсгийг чиглүүлж ажиллахаар боллоо. Иймээс 12 дугаар сарын 18-нд 20 гаруй эвсэл, холбоо, мэргэжлийн байгууллагуудад уг хуулийн төслийн ажлын хэсэгт төлөөллөө ирүүлэхийг хүсэж албан бичиг хүргүүлэв.

Дээрх уулзалтууд, хамтын ажиллагааны хүрээнд дараах байгууллагуудад мэдээлэл хүргэв.

- Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл
- Глоб интернэшнл төв
- Хэвлэлийн хүрээлэн
- Монголын телевизүүдийн холбоо
- Монголын өдөр тутмын сонины холбоо
- Парламентын сэтгүүлчдийн холбоо
- Монголын сайтын холбоо
- Монголын үндэсний сайтуудын хөгжлийн нэгдсэн холбоо
- Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо
- Хангарьд Улаанбаатарын сэтгүүлчдийн холбоо
- Орон нутгийн телевизүүдийн холбоо
- Өдөр тутмын сонинуудын эрэн сурвалжлах нэгдэл,
- Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв
- Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн эв нэгдэл ТББ
- Эдийн засгийн сэтгүүлч, шинжээчдийн клуб ТББ
- Засаглалд залуу сэтгүүлчдийн оролцоо ТББ
- Монголын криминологичдын холбоо
- Монголын гэрэл зурагчдын холбоо
- Талын түрлэг ТББ
- Монголын Олон Нийтийн Медиа Контент Сан
- Сэтгүүл зүйн инновац, хөгжлийн үүр төв зэрэг байгууллагууд багтаж байна.



Редакторуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулав.

- » “Цар тахлын үеийн редакцын бодлого ба өөрийн зохицуулалт” сэдэвт редакторуудын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд цар тахлын үеэр иргэдийн үнэнийг мэдэх эрхийг тэргүүнд тавьж, олон талын эх сурвалжаар баталгаажсан мэдээлэл бэлтгэх зорилгоо ухамсарлахын зэрэгцээ баталгаатай бус мэдээлэл түгээхээс сэргийлж, мэдээллийг нягтлан шалгадаг үр чадвараа улам хөгжүүлэх, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг чанд мөрдөн ажиллахыг редакцуудад уриалж Уриалга гаргасан. Мөн цаашид салбарын эрх зүйн асуудалд сонор хандах, редакторуудын клуб эсвэл зөвлөл байгуулах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрэв.
- » “Бүх нийтийн бэлэн байдлын үед сэтгүүл зүйд тулгарч буй асуудлууд” сэдэвт цахим уулзалтыг зохион байгуулав. Цар тахлаас шалтгаалан бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн цаг үед сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэхэд тулгарч буй асуудал, бэрхшээл, тэдгээрийг хэрхэн даван туулах талаар редакторууд санал бодлоо солилцлоо.



Редакторууд, сурвалжлагчид, редакцад зориулсан “Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцын баримтлах бодлого”, “Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг”-ийг санаачлан боловсруулж, салбарын эвсэл холбоод, редакцуудад хүргүүлэв.




Хэвлэл мэдээллийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг олон улсын байгууллагууд болох Дойче Велле Академи, Фридрих-Эбертийн сан, Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагааны нийгэмлэг, Их Британийн ЭСЯ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллалаа.



British Embassy
Ulaanbaatar

 Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг дэмжиж хэвлэл мэдээллийн болон бизнесийн байгууллагууд санхүүгийн дэмжлэг үзүүлээ.

- Бенекрафт ХХК
- Монгол Контент ХХК
- Монгол ТВ ХХК
- Отгонтэнгэр ИС
- ХХЗХ
- Мэдээлэл Холбооны Операторуудын Ассоциаци
- ОНХМХ
- А Стар Монголиа ХХК



 Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үүсгэн байгуулагчид болох Медиа консул клубийн гишүүдийн уулзалтыг зохион байгууллаа. Клубийг анх байгуулж байсан үеийн түүх болоод ХМЗ-ийн өнөөгийн байдал, хүрсэн үр дүн, амжилтын талаар гишүүд санал бодлоо хуваалцаж, цаашид ХМЗ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах, үр нөлөөг дээшлүүлэхэд зөвлөж, дэмжлэг үзүүлж байгаа илэрхийлсэн юм.



08 | САНХҮҮЖИЛТ

2020 онд ХМЗ нийт 112,015,556.64 төгрөгийн мөнгөн орлоготой, нийт 99,466,991.57 төгрөгийн мөнгөн зардалтай ажиллажээ. Орлогын бүрдэлт: дотоод эх үүсвэр 25.6%, төслийн эх үүсвэр 74.4%.

Орлогын эх үүсвэр нь хандив, хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг, төслийн үйл ажиллагааны орлогоос бүрдэж байна.

ХМЗ-ийн үйл ажиллагааны зардлыг төрлөөр харуулбал:


- Цалин, даатгал, татварын зардал 40%
- Ашиглалтын болон үйл ажиллагааны тогтмол зардал 31%
- Төслийн үйл ажиллагааны зардал 29%



ЗАРДАЛ:



ОРЛОГЫН БҮРДЭЛТ:



1

ХМЗ-ийн өнөөг хүртэл хуримтлуулсан мэдлэг, туршлага, уламжлалыг хадгалах замаар нийт гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх, улмаар өргөдөл гомдол барагдуулах үйл ажиллагааны чанарт ахиц гаргаж ёс зүйт сэтгүүл зүйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын хараат бус байдал, тогтвортой хөгжлийг дэмжих загвар бүхий хараат бус дэмжигч байгууллагыг хөгжүүлж, үр өгөөжийг хүртэх;

3

Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, сэтгүүлчдийг айдасгүй, аюулгүй, эрх зүйн таатай орчинд мэргэжлийн үүргээ гүйцэтгэх бололцоог нэмэгдүүлэхэд туслах;

4

Цар тахлын, сонгуулийн зэрэг нийгмийн онцгой нөхцөл байдалд хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, редакцын бие даасан хараат бус үйл ажиллагааг дэмжих чиглэлээр сэтгүүл зүйн болон олон нийтийн харилцааны ажлыг өргөнөөр хэрэгжүүлснээр иргэний мэдэх эрхийг хангаж, хэвлэл мэдээллийн найдвартай байдал, нэр хүндийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;



2020 ОНД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ДЭМЖСЭН БАЙГУУЛЛАГУУД

